



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Авто замын норм нормативын сан”-ийн хөрөнгөөр бий болсон, нийт 84,089,320.00 (наян дөрвөн сая наян есөн мянга гурван зуун хорь) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Зам, тээврийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн
019 дугаар тогтоолын хавсралт

№	Барилга, байгууламжийн нэр, байршил, зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)
		Хэмжих нэгж	Биет хэмжээ		
1	Нарны эрчим хүчний систем	40 кВт	1	2022	46,488,620.00
2	Автомашинны зогсоол бүхий нарны үүсвэрийн суурь	410 вт	32	2022	3,700,000.00
3	Явган замын халаагч систем	м	25	2022	8,000,700.00
4	Цахилгаан машин цэнэглэгч	кВт	7	2022	9,200,000.00
5	Онгрид системийн холболтын сүлжээ	125м		2022	8,500,000.00
6	Инвертер	40 кВт		2022	2,200,000.00
7	Гэрэлтүүлэг	ш	7	2022	4,200,000.00
8	Газардуулга	м	200	2022	1,800,000.00
	Нийт дүн				84,089,320.00 (наян дөрвөн сая наян есөн мянга гурван зуун хорь)